

СЭТГҮҮЛЧ С.ЦОГТСАЙХАНЫ
МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРЫН АСУУДАЛ

Б.Галаарид*

* Монголын Сэтгүүлчдийн Эвлэлийн ерөнхийлөгч, докторант

Түлхүүр үг: сэтгүүлчийн ур чадвар, нийтлэл, гарчиг, бичвэр, хөрөглөх чадвар, дүр

Сэтгүүлч хүнийг үнэлэх нэг гол хэмжүүр бол мэргэжлийн ур чадварын асуудал юм. Үүнийг судлаачид "Сэтгүүлч нь зүгээр л бичих төдий бус, сэтгүүл зүйн үйл ажиллагааны үе шат бүрт мэргэжлийн түвшинд ажил үүргээ гүйцэтгэх онол арга зүйн мэдлэг, чадвар эзэмшсэн байх учиртай"¹ хэмээн тодорхойлж байна.

С.Цогтсайхан нь мэргэжлийн сэтгүүлчийн хувьд энэхүү шаардлагыг хангаж чадсан нэгэн байсан бөгөөд түүний бүтээлд дүн шинжилгээ хийх явцад хэд хэдэн онцлог шинж ажиглагдсаныг тус бүрт нь авч үзье.

Гарчиг оновчтой өгөх чадвар. Сэтгүүлч хүний эн тэргүүнд эзэмшвэл зохих ур чадварын нэг нь гарчиг оновчтой өгөх чадвар юм. Сайн гарчиг нь уншигчийг өөртөө татаж, уг бичвэрийг унших санаа сэдлийг төрүүлдэг, тарвагачнаар зүйрлэвэл даллуур нь юм. Мэргэжлийн судлаачид үүнийг "Гарчиг бол бүх төрлийн бичвэрийн "Би энд байна" гэсэн зарлан тунхаглагч, "нэрийн хуудас" нь болдог"² гэж оновчтой тодорхойлсон байдаг.

Кино урлагт "Сайн зохиол киноны хагас" гэсэн хэлц үг байдаг. Түүнтэй адилхан сэтгүүл зүйд сайн гарчиг бичвэрийн хагастай тэнцэхүйц жин дардаг. Заримдаа бүтээлийнх нь агуулга мартагдсан атлаа гарчиг нь мөнхрөн үлдэж, бүр хэлц үг болон ардын ярианд хэвших нь бий. С.Цогтсайханд ч гэсэн дангаараа байхдаа ч амьдрах чадвартай гарчиг олон бий. Энэ бол түүний ур чадварын том үзүүлэлт мөн.

С.Цогтсайхан оновчтой сайн гарчиг өгөх урлагийг сайн эзэмшсэн уран бүтээлч байсан нь түүний бүтээлүүдээс тодорхой байна. Жишээ нь, Монголын зохиолчид хот хөдөөгийн хүн амыг хар цагаанаар ялгаж, баян хүн, хотын хүн хоёр хөдөлшгүйгээр эсрэг талын баатар болсныг шүүмжилж, үүнд хотод шигдээд хөдөөг магтан дуулдаг зохиолчид буруутайг өгүүлсэн нийтлэлдээ С.Цогтсайхан "Хотын ямаа" гэдэг гарчиг өгчээ.

"Хотын хүн нь бүү хэл ямаа нь ч гоочлогдоно. Хотын ямааг зам хөндлөн гарлаа, хог цаас идлээ, мод сүйтгэлээ, арай л хөдөөний ямааг хуурч мэхэллээ гэх нь холгүй. Энэ мэт "хотын" гэсэн хаягтай бүхэн зохиолын хуудаснаа ад шоо үзэгдэнэ. Энэ бүхнийг бичдэг Монголын "их" зохиол-

чид сүрэг сүрэээрээ хотод идээшээд л. Хотын ямааг хөдөө рүү туувал дуртайяа явж одохсон. Харин хотын зохиолчийг хөдөө хөөсөн ч явахгүй ажээ. Тэд хүүхэнтэй танилцахдаа "хотынх" гэж хэлэхээсээ сийхгүй. Цаасан дээр бичихдээ нутаг усаа үгүйлэн дуулж жинхэнэ "хөдөөний ямаа" болохыг эрмэлзэнэ. Ийм ч уул минь, тийм ч гол минь, өвс ногоо минь чамайгаа би зүүдлэн сэрлээ гэж ирээд золтой л үсээ зулгааж майлж босч ирэх нь холгүй" гэж өгүүлдэг энэхүү нийтлэлийн гарчигт салаа утга агуулагдаж байгаа нь бас сонирхууштай. Нэгдүгээрт, хотын гэсэн тодотголтой бүхнийг өмөөрч, нөгөө талаар хотод "ямаа" болон үржсэн зохиолчдыг шүүмжилсэн аясын аль алийг энэ гарчиг илэрхийлж байна.

Бичвэрүүдийнх нь "Гурван монгол зодолдоно", "Үхэлд арын хаалга бий", "Нохой зан, гахай авир", "Даатгалтай зүрхний цохилт", "Эцэг болох амархан, эцэг байх хэцүү", "Нийгмийн хурууны хээ", "Алж чадсан ч ялж чадахгүй", "Сохор нүдний нулимс", "Зээлгүй Монгол дээлгүй", "Өөрөө өвгөнтөд, бусад нь бургасанд", "Согогтой сонгуулийн солиорол", "Харанхуй хорвоо", "Гурван сөөм гээгтэй гудиггүй хөх өвгөн" зэрэг гарчгууд, номдоо өгсөн "Би дуугүй байж чадсангүй", "Тарчлаан" зэрэг нэр нь С.Цогтсайхан бүтээлийнхээ нэр гарчигт хэр ач холбогдол өгдөг байсны, үнэхээр гарчгийн мастер байсны нотолгоо юм.

Ардчилсан хөдөлгөөний С.Зоригийн үхлийн талаар удирдагч бичсэн нийтлэлээ тэрээр "Алж чадсан ч ялж чадахгүй" гэж нэрлэсэн бол ардчилсан хөдөлгөөнд анхнаас нь идэвхтэй оролцож явсан Н.Суурь өвгөнтэй хийсэн ярилцлагаа "Гурван сөөм гээгтэй гудиггүй хөх өвгөн" гэж гарчиглажээ.

Гарчгаа тодруулсан үг өгүүлбэрийг бичвэртээ заавал оруулж, гарчигтаа ч, бичвэртээ ч хүч нэмдэг нь түүний уран бүтээлийн онцлог арга юм. Жишээ нь, "Алж чадсан ч ялж чадахгүй" бичвэрээ "Зориг цуст мөргөлдөөнийг хэзээ ч хүсч байгаагүй юм. Харин өнөөдөр тэр цуст яргачдын гарт хорлогджээ. Балмадууд алж чадлаа. Харин ялж чадахгүй. Зориг маань зон олонтойгоо цуг үргэлж ялж

«

Бичвэрүүдийнх нь "Үхэлд арын хаалга бий", "Нохой зан, гахай авир", "Даатгалтай зүрхний цохилт", "Эцэг болох амархан, эцэг байх хэцүү", "Алж чадсан ч ялж чадахгүй", "Сохор нүдний нулимс", "Зээлгүй Монгол дээлгүй", "Өөрөө өвгөнтөд, бусад нь бургасанд", "Согогтой сонгуулийн солиорол" зэрэг нь С.Цогтсайхан гарчигт хэр ач холбогдол өгдөг байсны, үнэхээр гарчгийн мастер байсны нотолгоо.

»

байх болно" гэж төгсгөсөн бол "Гурван сөөм гээгтэй гудиггүй хөх өвгөн" гарчигтай бичил ярилцлагынхаа эхэнд "Н.Суурь Булган аймгийн Тэшиг сумын харьяат хүн. Залуудаа барилдаж явсан гэмээр бадриун чанга биетэй. Гурван сөөм гээгтэйхээ үзүүрт сур уясан, гутлынхаа ээтэн хогшоор дээр гаансаа балбасан, гудиггүй хөх өвгөн дүрээрээ мөн. Шулуун шударга үгтэй, аргил баргил дуутай, алиа хошин зантай төв халх" хэмээн гол баатраа зураглан тодотгосон байна.

Номдоо "Тарчлаан" гэдэг нэр яагаад өгсөн тухайгаа "Би" хэмээх нийтлэлдээ тэрээр ийн бичсэн байна.

...ТАРЧЛААН гэж яагаад нэрлэв. Би хөдөө суманд амьдарч үзээгүй, тэнд төрөө ч үгүй. Би хотын 40 мянгатын дулаан байшинд эхээс мэндэлж "Их дэлгүүр" хавьцаа тоглон өссөн. Тэгсэн хэрнээ би хөдөө суманд амьдарч суугаа хүмүүсийг яагаад ч юм өрөвдөж хайрлаж суудаг юм. Надад очоогүйгээс очсон сум нь олон. Яах гэж хүмүүсийг уул уулын мухарт сум гэсэн цөллөгөнд хашдаг юм бэ гэж би тарчилсан юм. Мөн түүнчлэн хүн хөдөлмөрлөхгүй байж дандаа хялбар хоол, бэлэнчлэх сэтгэлгээг хайж байдагт нь тарчилсан юм. Яагаад бид ийм уудам сайхан нутагт төрчихөөд газаргүй хүн шиг ядуу амьдардагт би тарчилсан юм. Мөн сайн сайхан хүмүүс зальжин хүмүүсээс дорд яваад, аугаа их хүмүүс яагаад торойж түрүүхгүй яваад тарчилсан юм.

Миний тарчлаан хайраас төрсөн байж болно. Энэ "хайрын" төлөө миний ном өөрөө бүтсэн байж болно...

С.Цогтсайханы зарим нийтлэлийн гарчгаас тэр бичвэрийн агуулга, ач холбогдол шууд харагддаг. Өөрөөр хэлбэл тэрээр хэрэгтэй үедээ оновчтой гарчгаар уншигчаа даллаж чаддаг хүн. Түүний жишээ бол "Даатгалтай зүрхний цохилт", "Найман зуун нэгүүлээ нийлж нам болж тоглоё", "Чонын үүргийг архи гүйцэтгэнэ" зэрэг нийтлэл юм.

1997 онд бичсэн "Даатгалтай зүрхний цохилт" нийтлэлдээ тэрээр эрүүл мэндийн даатгалын системд өөрчлөлт хэрэгтэй байгаа, иргэн хүн өөрийн сонгосон эмнэлэгтээ сар бүр татвараа төлдөг зарчим хамгийн үр ашигтай гэдэг асуудлыг хөндсөн нь өнөө ч ач холбогдлоо алдаагүй байна. Архидалтын асуудлыг хурцаар хөндсөн өгүүлэлдээ тэрээр "Чонын үүргийг архи гүйцэтгэнэ" гэсэн гарчиг өгсөн нь чоно байгалийн цэвэрлэгч, архи нийгмийн

цэвэрлэгч гэсэн гашуун үнэнийг ил тодоор сануулсан хэрэг юм.

"Унтахын өмнө архи уухад сайхан нойрсоно. Гэхдээ үүрд унтаж болно гэдгийг бас санагтун.

Өтөлсөн муу бугыг өлөн чоно зооглоно.

Өөдгүй муу хүнийг шилтэй архи залгина.

Ингэж байгаль цэвэрлэгдэж шинэчлэгдэнэ. Тэгж хүний нийгэм хог шороогоо шүүрдэнэ" гэж уг нийтлэлээ төгсгөсөн нь гарчгийнхаа утга санааг тодруулан тодотгосноос гадна архичин хүн хэрхэн нийгмийн хог шороо болж адшоо үзэгддэгийг шулуухан хэлснээрээ хүчтэй мессеж үлдээж чадаж байна. Энэ бол гарчиг, бичвэр хоёр уншсан хүний дотоод сэтгэлийг хэрхэн нэгэн хэмээр хөндөж, улмаар давхар цохилт үүсгэж, тэгснээрээ урт удаан хугацаанд сэтгэл оюунд хадгалагдах боломжтой болдог нууцыг нээж чадсан уран бүтээлчийн хэрэглэдэг арга юм.

“Н айман зуун нэгүүлээ нийлж нам болж тоглоё” нийтлэл гэхэд л улс төрийн нам байгуулахын тулд 801 хүн байхад л хангалттай гэж заасан хуулийн гажгийг шүүмжилсэн нь гарчгаасаа тодорхой байна. Ийм маягаар бий болсон жижиг намд дотоод зөрчил гэж байдаггүй, ихэвчлэн нэг хүний хувийн өмч мэт байдаг дутагдлыг С.Цогтсайхан энэ нийтлэлдээ шүүмжлээд “Надтай нийлж нам байгуулах найман зуун товарищ байна уу? Би дарга нь болно шүү” гэсэн егөө асуулт-анхааруулгаар өндөрлөсөн нь гарчгийнхаа агуулгыг гүнзгийрүүлсэн сайн төгсгөл болжээ.

Хөрөглөх чадвар. Сэтгүүлч С. Цогтсайханы мэргэжлийн ур чадварыг тод томруун харуулж чадах бичлэгийн төрөл зүйлийн нэг нь хөрөг юм. С.Цогтсайхан нь шог зохиолч Цэндийн

Доржготов, "Чингис хаан" хамтлагийн ахлагч Жаргалсайхан, улс төрч Э.Бат-Үүл, Ц.Элбэгдорж, Хамрын хийдийн тахилч Х.Алтангэрэл, Хөвсгөл аймгийн Цагаан-үүр сумын эмч Энхжаргал зэрэг янз бүрийн ажил мэргэжилтэй олон хүний тухай хөрөг таталбар хийсэн нь судалж суралцууштай чухал хэрэглэгдэхүүн болж байна.

Тэдэн дундаас Булган аймгийн Тэшиг сумын эгэл нэгэн өвгөн Лхагваагийн тухай 1993 онд бичсэн "Чимэггүй хөрөг"-ийг нь эн тэргүүнд нэрлүүштэй. Энэ хөрөг энгүүн хүүрнэлээр эхэлнэ. Тэгээд гол баатарынхаа туулсан амьдралын бартаа нугачаа, алдаа оноог товчхон боловч нэгд нэггүй өгүүлнэ. Дараа нь гадаад байдал, зан чанарыг нь ийн зураглажээ:

"Хэдэн уулынхаа дунд төрөөд хэдэн уулынхаа дунд элэгдэж яваа хөгшнийг Лхагваа гэхээсээ сумын заан гэх нь илүү.

- 73 наслахдаа юу үзэв? гэхэд

- Үхэхээс бусдыг үзэж үхээрээс бусадтай нөхөрлөв гэж хэлнэ.

1945 оны Чөлөөлөх дайнд оролцож нуувчинд нугдайж, давшилтанд орохдоо гүрээгээ чинэртэл "Ура!" хашгирч, айх үедээ айж, айлгах үедээ айлгаж, үхэхээс бусдыг үзжээ.

Амьдралын алтан үе нь барилдаж явсан цаг нь. Унасан газар. угаасан ус нь болох Булган аймгийн Тэшиг сумын наадамд зургаан удаа түрүүлжээ. Тэшигтэй залгаа Хөвсгөлийн Тариалан сумын наадамд хоёр удаа ногт ганзагалж очоод хоосон эргэж ирсэн удаатай. Гэвч гуравдахьдаа түрүүлж даага хөтөлж ирсэн хүн. Моринд дуртай. Морь хулгайлж яваад баригдаж шоронд суусан. Суллагдаад нөгөөх л бүдүүн зангаараа аашилж яваад хүн зодож дахин суусан. Торны

цаана хэдэн жил өнгөрүүлэхдээ ёстой л үхээрээс бусадтай нөхөрлөж үзжээ.

Сайхан том чихтэй, барзгар улаан нүүртэй, бүдүүн баргил дуутай, шооч, Гар нь хүрз мэт, хуруу мойног том, Алиа хошин зантай хүн. Дал гарсан атлаа нэг ярьсан юмаа давтдаггүй, байнга өөр сэдвээр хошигнож, алиалж явдгийг нь би гайхаж билээ..."

Доктор С.Батбаатар уран сайхны болон сэтгүүл зүйн зураглалын ялгааг тайлбарлахдаа "Сэтгүүл зүйн зураглал нь бодит байдлыг хуулбарласан зураг, түүнийг үгээр дүрслэн буулгасан илэрхийлэл байдаг учраас зорилгоосоо үүдэн, уянгын халил, сэтгэлийн хөдөлгөөний өнгө аяс илэрхийлэх зэрэг уран сайхнаас ангид энгийн дүрслэл, найруулга голлодог онцлогтой" гэсэн байдаг. С.Цогтсайханы хөрөг бичвэрүүдээс энэ онцлогийг илүү тод харж болно.

Дээр өгүүлсэн хөргийн араас өвгөнтэй ярьсан харилцан яриаг оруулснаар хөрөг таталбараа илүү амьд, үнэмшилтэй болгосон байна. Хааяа ходоод нь өвдөхөөр уудаг эмийнхээ нэрийг мэдэхгүй "Хүн л өгсөн юм" гэж суугаа нь хөгшнийг хэр хэнэггүй нэгэн болохыг харуулна. Цөөхөн хэдэн хониноосоо нэгийг гаргаж өгөхөөр зүтгэж, хэрэггүй гэж хориход "Хөгшин би өгнө гэж байхад миний хүүгийн хэрэггүй ч дүүрчээ" гэх үгнээс нь зочломтгой, найрсаг, бас дураараа зан мэдрэгдэнэ. Хөргийн төгсгөл хэсэг ч хийцийн хувьд яалтгүй анхаарал татна.

"- Баяртай Лхагва гуай. Би таны тухай бичнэ ээ.

- Буруу хойшоо бол доо. Гавьяа хийсэн биш, гай л тарьж явсан байх.

Тийм ээ, Лхагва гуай 5 жилийн гавшгайч биш. Аварга малчин ч биш. Төлөвлөгөөгөө байнга давуулан биелүүлдэг ч хүн биш.

Утаан дунд буу үүрээд үхэлтэй мөргөлдөн гүйж явсан, арван үхрээ туугаад нэгдэлд орж байсан, адуу хулгайлаад шоронд суусан, сумын наадамд 6 түрүүлсэн, айл хэсч аяга тагш юм уусан, ач гучаа өвөр дээрээ эрхлүүлсэн, үхэхээс бусдыг үзэж үхээрээс бусадтай нөхөрлөж явсан хүн.

Лхагва гуай, би таныг хоосон магтаж элдэв өнгөөр эрээлэн будсангүй.

Таныг тийм чимэгтэй, давстай юманд дургүйг би мэднэ. Та гашуун ч гэсэн үнэнд дуртай. Бас гашуун архинд дуртай. Би танд архиа битгий уугаач гэж хэлэхгүй.

Үнэн дүнжгэр уулсынхаа дунд ууж, дуулж яв даа.

Эл таталбарыг бичсэнээс хойш хоёр жилийн дараа Лхагва гуай бурхан болсон юм. Яг л амласан 75 насаа хүрсэн дээ, хөөрхий".

Сэтгүүлч С.Цогтсайхан энэхүү хөргөө өндөрлөхдөө эхэн хэсэгт өгүүлсэн дээрээ дунд хэсгийн харилцан ярианаас тодорхой болсон зарим мэдээллийг нэмэн товч давталт хийгээд "Үнэн дүнжгэр уулс дундаа ууж, дуулж л яв даа" хэмээсэн уянгалаг төгсгөлөөр хашсан нь оновчтой шийдэл болжээ. Харин "Эл таталбарыг бичсэнээс хойш хоёр жилийн дараа Лхагва гуай бурхан болсон юм. Яг л амласан 75 насаа хүрсэн дээ, хөөрхий" гэсэн өгүүлбэрийг дараа нь номд эмхтгэхдээ нэмсэн бололтой байна.

С.Цогтсайханы "Алж чадсан ч ялж чадахгүй" нэртэй нийтлэлийн эхний хэсэг үндсэндээ улс төрч С.Зоригийн хэн болохыг өгүүлсэн хөрөг юм. Ардчиллын үйл хэргийн төлөө цугтаа тэмцэж явсан улс төрчийн хувьд тэрээр С.Зоригийг нэн сайн мэддэг байсан учраас маш товчхон боловч уншсан хүнд тэр хүн хэн байв гэдгийг сайтар

ойлгуулж чадахуйц зураглал бүтээсэн нь "Зориг анд минь насандаа багтамгүй хэрсүү хүн байж дээ. Улс төрийн том алхам хийхдээ ул суурьтай хэрнээ амьдралын аар саархан юманд мөн ч гүндүүгүй эр сэн. Зангиагаа хайш яашхан зангидчихаад хямдхан тамхи зууж, хэнтэй ч хамаагүй шатар тоглоод хэг хэг инээж явдаг нь санаанд тод оо. Элдэв шуналгүй, алив зүйлд цамаан зан гаргадаггүй л хүн. Алив асуултын хариуг маш үндэстэй нэг л хариултаар өгдөг, цөөн үг, цэгцтэй бодолтой, шулуун зантай, бялдууч бөөрөнхий байдлыг үл тэвчдэг байсан нь муу хүмүүсийн дургүйцлийг хүргэдэг ч байсан байж болно. Эрдэмт хүн даруу, их мөрөн дөлгөөн гэдэг үг Зоригт зохисон санагдана. Улс төр гэдэг нь хүмүүсийг цэцэн үгтэй, лобби сайтай, биеэ авч явахдаа "муу санаатай", хэнд долигонож, хэнээс "очков" авахаа мэддэг гэх мэт олон юманд сургадаг. Харин талийгаач маань зүгээр л номын хүн байсан юм" гэсэн эхлэлээс тодорхой байна.

С. Цогтсайханы хөрөг бичвэрүүдээс анзаарагдаж буй нэг онцлог бол гол баатар болгон дахин давтагдашгүй өөр өөр шигээ тэдний тухай бичсэн бичлэгийн хэлбэр болгон нь бас ондоо ондоо байгаа явдал юм. Түүний хөрөг нийтлэлүүдээс ийнхүү дахин давтагдсан, хэвшмэл уйтгартай байдал анзаарагдахгүй байгаа нь сэтгүүлчийн мэргэжлийн ур чадвар өндрийн нотолгоо юм.

Тухайлбал, "Тарчлаан" номдоо зориулан бичсэн "Би" хэмээх өөрийн хөрөг (автопортрет) нь түүний өөрөө өөрийгөө зурагласан ер бусын бүтээл билээ.

Энэ хөрөг "Би гойд хүн биш. Хүний олон сайхан чанараас жирийн байх л

надад таалагдана. Тиймээс ч миний бичсэн бүхэн жирийн байгаасай гэж хүсдэг. Өөрөө ч жирийн амьдрахыг боддог. Амьдралдаа оносон алдсанаа дүгнэх дургүй. Дүгнэх юм бол гол харлуулсан алдаа маань их. Би шүтлэггүй. Гэхдээ нүгэлгүй явбал бурхан тусална гэдэгт итгэнэ. Түүнээс биш олон мянган удаа сунаж мөргөөд аз жаргал ирнэ гэдэгт итгэдэггүй. Хар цагаан, гэрэл сүүдэр, өдөр шөнө, сайн муу, жаргал зовлон гэсэн ээлжлэх тавиланд бол яг итгэдэг. Тийм болохоор зовбол жаргана, өвдвөл эдгэнэ, уруудвал өөдлөнө гэсэн сүсгээр өөрийгөө аргадаж, учирсан гайгаа давах сэтгэлийн хүч сэлбэдэг. Харин би ногоон өнгөнд дуртай нь сонин" гэж эхэлдэг.

Өөрийнхөө сул тал, хүсэл мөрөөдөл, амьдралд хандах хандлага, ертөнцийг үзэх үзлээ энгүүн хүүрнэж, улмаар цайлган цагаан сэтгэлдээ яагаад дургүйгээ учирлаж, тэгснээрээ өөрийгөө хэн бэ гэдгээ тодруулж, гэнэн цагаан үйлдлийн улмаас гомдоосон нөхдөөсөө битүүхэндээ уучлал эрсэн нь ч бас л хөрөгт нэмсэн таталбар, өөрөөр хэлбэл уран чадварын илэрхийлэл юм.

"Өндөр нуруутай болж төрөөгүй маань азгүй хэрэг. Яагаад гэвэл би нуруулаг бүсгүйд дуртай. Тэд намайг төдийлөн тоодоггүй. Гэхдээ би олсон хүртсэн бүхэндээ сэтгэл хангалуун, ад шуналгүйдээ баярладаг. Миний хамгийн арчаагүй чанар бол хүнд муу санаж чаддаггүй цагаан сэтгэл юм. Цагаан сэтгэл гэдэг нь хүүхдэд л зохидог болохоос насанд хүрсэн хүнд байж боломжгүй юм. Дэндүү цагаан сэтгэл нь заримдаа дотны хүмүүсээ ихээр гомдоож хожмын гай зэтгэрийг ч дууддаг. Нөхрийг гомдоох үг миний цагаан сэтгэлгээс л гардаг. Яагаад гэвэл би түүнийг гомдоосноо мэддэг.

гүй. Юу гэж хэлснээ ч мартчихдаг. Тийм болохоор би цагаан сэтгэлд дургүй".

Үүний араас хувь хүний дотоод ертөнцийн зураглал буюу үхэл, амьдралын талаарх ойлголт, амьдралын зорилго, юуг үнэт зүйл гэж үздэг, бусдын шунан дурладаг амьдралын хэв маягт хэрхэн ханддагаа илэн далангүй, энгүүн хүүрнэснээр өөрийн хөргөө илүү уран нарийн, тодорхой болгож чадсаныг дараах ишлэл харуулна.

"Үхэхээс нэг их айдаггүй. Харин утгагүй үхлээс айдаг. Архи ууж байгаад ч юм уу, эсвэл согтуу галзуу юмны гарт өртөх, шал дэмий усанд сэлж байгаад живэх, зүгээр л хальтирч унаад мажийвал утгагүй.

Амьдралын зорилго минь баян чинээлэг байж, сайхан машин унаад, сархад зооглож хүүхэнтэй зугаалах биш л дээ. Зөвхөн л үр хүүхдийн минь цаашдын заяа. Миний хүү усанд унажээ гэхэд би далай ч байсан араас нь эргэлзэхгүй үсэрнэ. Гэхдээ би коммунист биш болохоор баян чинээлэг байхыг хүсэлгүй яахав. Сайн хүүхэн, сайхан дурлалаас яалаа гэж буцахаа.

Ан хийж, мөрийтэй билльярд тоглож, казиногоос мөнгө хожих нь мундаг эрийн шинж гэж үздэггүй".

Сэтгүүлч С.Цогтсайхан ийнхүү өөрийн хөргийг бүтээсэн нь Монголын сэтгүүл зүйд төдий л анзаарагдаагүй шинэлэг алхам болсныг тэмдэглэх хэрэгтэй. Яагаад гэвэл автопортретийг зураачид л зурдаг гэсэн ягшмал ойлголт байдаг. Тэгвэл сэтгүүлч хүн ч үгээр өөрийгөө зурж болох нь гэдгийг тэрээр нотолсон юм.

Шог зохиолч Цэндийн Доржготовын тухай хөрөг таталбараа тэрээр зүгээр л "Цэндийн Доржготов" гэж нэрлэжээ.

Сонин содон гарчиг олж чадахгүйдээ бус, харин Цэндийн Доржготовын тухай "Хонх"-ын Цогтсайхан юу бичиж вэ гэдгийг уншигч мэдээж сонирхоно гэдэг үүднээс ийм энгийн гарчиг өгсөн гэмээр байна. Энэ бол гарчиг өгөлтөд хэрэглэдэг олон аргын нэг, тэгэхдээ бичигч өөртөө итгэлтэй байгаа үедээ хэрэглэдэг арга билээ.

Хөрөг нийтлэлийн эхлэл нь ч гэсэн анхаарал татна. Тэрээр гол баатрынхаа талаар эхэлж дурдсангүй. Харин хүнийг уурлуулах, уйлуулах, инээлгэх талаар ярьж эхэлжээ.

"Хүнийг уурлуулах амархан. Тэр тусмаа монгол хүнийг уурлуулахад хамрыг нь сөргөөх тедийд өрвөлзөөд ирнэ. Хүнийг уйлуулах амархан. Тэр тусмаа Энэтхэг кино үзээд уйлчихдаг монголчуудыг уяраахад түвэг удахгүй. Харин инээлгэх хэцүү. Монголчууд инээхийн тулд Батзаяагийн тоглолтын билетийг өндөр үнээр авч байна. Гайхалтай нь юу вэ гэвэл бүх тоглолтын билет нь дуусчихаад огт олдохгүй байгаа явдал юм. Ингээд билетийн үнэ шаглагдаж эхэллээ. Инээд ийнхүү үнэ хүрч байна. Инээд хүмүүст ийм их хэрэгтэй байна".

Улмаар хүмүүст ийм их хэрэгтэй байгаа инээдийг үйлдвэрлэгч шог зохиолчдын эмгэнэлт хувь заяаны талаар "Харин шог зохиолчид уйтгар гунигтай сууна. Шог зохиолч хүн үеийн үед дээдсүүдэд адлагдсаар ирсэн болохоор тэдний түүх голдуу шорон гяндан, цөллөг, хавчлага мөрдлөг гэсэн гунигийн хар мөрөөр дүүрэн байдаг юм. Аливаа шог зохиол нь тухайн нийгмийнхээ дутагдлыг шүүмжилж, дарга ангийн далд нүүр царайг илчилж байдаг болохоор ихэс дээдэст таалагддаггүй юм" хэмээн эсрэгцүүлэн өгүүлээд, тэндээсээ Доржготов гэгч хэн болох тухай хэсэг рүү шилжжээ.

Тэгэхдээ зүгээр л хуурай тоочихыг урьтал болгосонгүй. Шог зохиолын олон улсын уралдаанд Туркийн алдарт шогч Азиз Несиний өмнө орж, дэд байр эзэлж явсан түүхээс нь хүүрнэн түүний зиндаа эрэмбийг мэдрүүлээд, уран бүтээлийнх нь талаар ярилцан нэмэлт мэдээлэл өгч, дараа нь Ж.Барамсай, Б.Цэнддоо зэрэг шогчдын үгээр бататгал хийсэн нь үхрийн бөөр мэт алаг эрээн санагдаж мэдэх боловч бичвэрийг бүхэлд нь аваад үзвэл монгол бөхийн уран сүлжээ-угсраа мэх мэт даацтай болжээ.

Хөргийн гол баатар Архангайн Хашаатад хонь хариулж яваа тухай эцэст нь дуулгаад "Хошин шогч хүн хонь хариулж явна. Хошин шогчоор хариулгаж яваагаа хонь өөрөө мэдээгүй явна. Төр засаг түүний адил мэдээгүй л явна" гэсэн хонь шиг үүлгэр төрийг чимхсэн хошин агаад хүчтэй төгсгөл хийсэн нь хошин шогчийн тухай хөрөгтөө таарсан уран шийдэл болжээ.

Улс төрийн нийтлэлч. С.Цогтсайханы бүтээлд хамгийн гол байр суурьтай сэдэв бол улс төр юм. Тэгэхдээ сэтгүүл зүйн гол зарчим болох тэнцвэртэй байдлыг улс төрийн тэдгээр нийтлэлээс барагтай бол олж харахгүй. Гэхдээ үүнд тулхтай гэмээр зөвтгөл бий. Тэр нь тухайн цаг үе. Нийгмийн өөрчлөлт шинэчлэлийн язгуур утгыг олонх ойлгоогүй, шинэ хуучны зөрчил тэмцэл их, ардчилсан хувьсгалын мөн чанарыг ухуулан ойлгуулах нь нэн чухал байсан он жилүүдэд бүтээж туурвиж явсан нь түүний уран бүтээлд тусгалаа олсон байна.

Ийм нөхцөл байдал манай сэтгүүл зүйд өмнө нь ч тулгарч байсныг судлаач Л.Норовсүрэн "Монголын тогтмол хэвлэлийн нийтлэлд дөчөөд оныг хүртэл илчлэн шүүмжлэх, ухуулан сурталчлах чиглэл давамгайлж байжээ.

Энэ нь нэг талаар хуучин шинийн зөрчилтэй, нөгөө талаас тухайн үеийн уншигчдын боловсролын түвшинтэй холбоотой байв"⁴ хэмээн дүгнэн бичсэн нь бий.

Энэ байдал нийгмийн шилжилт болох бүрт хурц тодоор илэрдэг зүй тогтолт үзэгдэл бололтой.

С.Цогтсайханы "Ирж яваа цаг", "Итгэл", "Энхрий намын ивээлээр", "Ардчилсан хүчний лидерүүдэд илгээх захидал", "Согогтой сонгуулийн солиорол", "МЧАСЭ, Н.Багабанди хоёр", "Би яагаад Монголын ардчилсан холбоонд элссэн бэ?", "МоАХ-ны тухай бид юу мэдэх вэ?", "Ардчиллын баярыг тэмдэглэх өдөр ирнэ" зэрэг олон нийтлэлээс тухайн цаг үеийн Монгол орны улс төрийн амьдралын өнгө төрх, улс төрийн намуудын асуудалд хандаж байсан хандлага, хувь улс төрчдийн байр суурь зэрэг тодорхой харагддаг.

Гэхдээ С.Цогтсайхан бол зүгээр нэг сэтгүүлч биш, улс төрийн "Шинэ үе" бүлгэмийг үүсгэн байгуулалцаж, залуучуудад хандсан ухуулах хуудасны эхийг зохион гудамж талбайд нууцаар нааж, тарааж явсан тэмцэгч, Монголын ардчилсан холбоог үүсгэн байгуулсан "Ардчиллын 13"-ын нэг, насан эцэслэлтээ ардчиллын төлөө санаа зовниж явсан улс төрч учраас түүний сэтгүүл зүйн бүтээлүүд, ялангуяа улс төрийн нийтлэлүүдэд нь нэг талыг барьсан, хувийн үзэл бодлоо илэрхийлсэн, намын байр сууриа хамгаалсан байдал ажиглагддагийг анхаарч, сэтгүүлчийн уран чадварын асуудлыг нь ялгаж салгаж судлах нь зүйтэй гэж үзэж байна.

Хэдийгээр түүний бүтээлд тухайн үеийн улс төр ийнхүү гүн гүнзгий нөлөөлсөн ч гэлээ шударга байх, үнэний талд зогсох сэтгүүлчийн сэтгэл зүрхний дуудлагаас тэрээр хазайж

байгаагүй нь улс төрийн өрсөлдөгчдөө төдийгүй, өөрийн хамтран зүтгэгчдээ ч хайр найргүй шүүмжилж байснаас тодорхой харагддаг. "Ардчилсан хүчний лидерүүдэд илгээх захидал" нь үүний сонгодог жишээ гэж хэлж болно. Энэ нь нэг талаар улс төрийн агуулгатай захидал, нөгөө талаар сэтгүүл зүйн бүтээл юм. С.Цогтсайхан энэхүү захидал-нийтлэлдээ "Хэдэн хүн нийлээд холбоо, нам гэгч юм байгуулж болдог юм байна гэдгийг анх МоАХ, МоАН ойлгуулж өгснөөр хүмүүс звсэл холбоо байгуулж сүржигнэхийн дон шүглэж, бүгд л дарга, тэргүүн, ерөнхийлөгч болохын хүсэлд автав.

Д олигоноод яахав, шууд үнэнийг хэлэхэд МоАН-ыг дэмжигч мянга мянган гишүүдийн цуглааныг ашиглаж МСДН, МҮДН хоёр мэндлээд авсныг хүн бүхэн мэдэж байгаа. Нэг цуглаан дээр нэг нам төрөөд байхаар МоАХ-ны гишүүд эхэндээ баярлаж алга ташаад байснаа сүүлдээ гайх-ширч "Энэ чинь юу гээч болоод байнаа" хэмээн алмайраад хөшиж орхисон юм. Олон нам төрж хүмүүсийг олон тийш нь хувааж, ардчиллын хүчийг сарниулж байна гэдгийг хүмүүс сүүлд ухаараад нэлээд бухимдаж, бие бие рүүгээ ил далд чулуу шидэх болсон. Ингэж Монголын ардчиллын хүч анхныхаа цууралтыг авсан юм. Хожим нь намуудын тоо 13 хүрч, дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга нарын тоо 100 гарав.

Цуглаан дээр үг хэлэх дуртай байсан бүх л хүн дарга болоод зогссонгүй, тэр ч тэнэг, би ч цэцэн гэх маягийн юм ярьж, өчигдөр ямархан хөөрхөн жаал дотоод пальтоны зах босгоод хөлөө хавчиганан зогсож байснаа умартав" хэмээн ардчиллын эхэн үеийн үйл явцыг эргэн сануулсан

нь түүхийн нэгэн зурвас үеийн тодотгол төдийгүй, түүнд биеэр оролцож явсан хүн өөрөө тэр үеийн байдлыг дүрсэлсэн, хамгийн гол нь түүхэн үйл явдалд магнайлан оролцогсод өөрсдөө энэ талаар ямар ойлголт, хандлагатай байсныг нотолсон үнэт баримт болжээ.

Улмаар ардчилагчдын дунд үүссэн хагарал цаашид хэрхэн даамжирсныг өгүүлэхдээ "Нэгдмэл нэг хүч болох тухай огт бодохоо байгаад "нэг ноймрын хүн" болох өвчинд нэрвэгдэв. Хүн ер нь хэдэн ч нам байгуулж хаашаа ч холбирч тоглож наадаж болно гэдгийг С.Зориг өөрийн биеэр үлгэрлэв. Хөрвөөгөөд л, шарваганаад л, энд тэнд үсчээд эцэст нь Нэгдсэн нам хэмээх хий үзэгдлийн "Нүцгэн ноён" болов. Хүн ер нь яаж дураараа аашилж өөрийнхөөрөө муйхарлаж зүтгэж болдог жишээг Э.Бат-Үүл биеэрээ үзүүлэв. Нөхдийн үгийг үл хэрэгсэн, гол зогцоо асуудлыг зөвхөн дарга лидерүүдийн хүрээнд шийдсээр ирсэн тэрбээр өнөөдөр ШҮХН гэгчийг мөн л лидерүүдийн хүрээнд ярьж тохирчихоод сууж байна" хэмээн хурцаар шүүмжилжээ.

Энэ ил захидал нь нэг талаас улс төрч Цогтсайханы үзэл бодол, байр суурийн илэрхийлэл, нөгөө талаас сэтгүүлч Цогтсайханы улс төрийн нийтлэл юм. Нийтлэл гэдэг утгаар нь авч үзвэл тэрбээр зөвхөн түүх өгүүлж, өнөөгийн байдлыг шүүмжлээд зогссонгүй, асуудлыг шийдэх зам, гарцыг нь бас хэлж өгсөн байна.

"Хэрэв бид нэр алдрын төлөө тэмцэл хийгээгүй л юм бол, Хэрэв бид "нэг ноймрын хүн л байхын төлөө" тэмцэл хийгээгүй юм бол, "Ардчилсан нам" хэмээх товч тодорхой нэрийн дор нэгдэхийг уриалж байна. Нэгдвэл нэгдсэн шиг, хийвэл хийсэн шиг, хоёрын хооронд чиний, миний, тэдний

гэлгүйгээр, хоорондоо хөлөө жийлцэж хүний идэш бололгүйгээр "Коммунист үзэл суртал, нэг намын ноёрхлын" эсрэг хүчээ нэгтгэцгээе" хэмээн гарах гарц, арга замыг тодорхойлсон байна.

Улс төрийн сонгуулийн сэдэв манай сэтгүүл зүйн хамгийн түгээмэл сэдвийн нэг юм. Энэ сэдвээр олон сэтгүүлч бичдэг боловч сэтгэгдэл, санал бодол, баримтгүй хоосон цэцэрхэл голлодог. Зад шүүмжлэх авч тэр нь эзэн биегүй, ерөнхий учраас үр дүн ч, үнэ цэн ч байдаггүй. Тэгвэл С.Цогтсайхан сонгуулийн тухай бичихдээ асуудлын мөн чанарыг ухуулан ойлгуулах, болох болохгүйг эзэн биетэй өгүүлэхийг хичээсэн байна. "Соготой сонгуулийн солиорол" нийтлэлийнхээ эхэнд тэрээр сонгуулийн ямар солиорол Монголд нүүрлэснийг өгүүлжээ.

"Сонгуульд оролцох хүн эхлээд ажлаасаа гардаг. Ажлаа хүлээлгэж өгсний дараа сонгуулийн кампания эхэлдэг дэлхий нийтийн туршлага байна. Манайх ажлаа хийхийн зэрэгцээ сонгуульд өрсөлддөг. Нэгдүгээрт, энэ хүн ажлаа огт хийхгүй гэсэн үг. Хоёрдугаарт, энэ хүн өндөр ажил алба хашдаг бол албан тушаалаа өөрийнхөө сонгуульд заавал ашигладаг. Дэлхийн жишгээр бол сонгуульд өрсөлдөөд ялагдсан бол ажилгүй хоосон үлддэг. Манайд бол хуучин ажилтайгаа үлдэнэ. Хүн ажлаасаа халагдаад сонгуульд өрсөлдөнө гэдэг бол иргэний асар их зориг. Сонгуульд ялна гэж итгэсний илэрхийлэл. Сонгуульд өрсөлдөөд үзье, яавал ч яаг гэсэн хэллэг Монголд л байна. Үзээд алдъя гэдэг маань ялагдсан ч хуучин ажилтайгаа үлдэх хүний үг".

Ийнхүү гол санаагаа хэлсний дараа тэрээр тодорхой эзэн биетэй баримтаар энэхүү гаж солиорлыг давхар давхар баталсан байна. Тэгэхдээ тухайн

үед нөлөө бүхий албан тушаал хашиж байгаа нэр бүхий хүмүүсийн ёс суртахуунгүй үйлдлийг илчилсэн байна.

"Өнөөдөр Монгол улсын төрийн машин яг таг зогссон байна. УИХ завсарласан. Засгийн газар ажиллахгүй байна. Яагаад гэвэл Ерөнхий сайд нь сонгуульд өрсөлдөөд явчихсан. ЗГХЭГ-ын дарга мөн сонгуульд мордсон. Бүх сайд нар сонгуульд хамрагдаад улс орон огт эзэнгүй айл болчихоод байна. Дэд бүтцийн сайд Батхүү 10-20 машин хөлөглөн хөдөөгөөр баахан хурдан морь, бөх ярьж "Намайг сонгоорой" гээд хөрөнгөөр туйлж яваа сурагтай. 20 орчим жил машин Батхүүгийн өмч мөн үү? Түүнд хэрэглэгдэх бензин түүнийх гэж үү? Гадаад харилцааны сайд Туяа ч мөн адил яамныхаа хэдэн олигтой машиныг хөлөглөөд Хэнтийд давхиж яваа гэнэ. Радио Телевизийн дарга Билигт Баянхошуунд антенн бариулаад өөрийнхөө мөнгөөр бариулсан юм шиг сонгуульд найдвар тавьж байна".

2000 онд болж өнгөрсөн УИХ-ын сонгууль тойрсон халуурал, солиорлыг ийнхүү хоёр хуудас хүрэхгүй бичвэрт шингээсэн нь сэтгүүлчийн, тэр дундаа улс төрийн сэдвээр бичдэг сэтгүүлчийн бүтээл түүхийн ямар үнэт баримт болдгийн баталгаа болон үлджээ. Түүнээс гадна хэт ерөнхий асуудлаар хэт олон баримт ашиглан бичих гэсээр зарим сэтгүүлч асуудлын голыг олохгүй

нурших, баримтууддаа түүртэн төөрөлдөх явдал байдаг. С.Цогтсайханы энэ нийтлэл тийм хүмүүст товч, тодорхой, ойлгомжтой, тэгэхдээ бүрэн гүйцэд бичихийн жишээ болж чадахаар байна.

Ер нь С.Цогтсайханы улс төрийн сэдэвт бичвэрүүдэд түгээмэл анзаарагддаг нэг онцлог нь сэтгэлийн хөөрлөө хурцаар илэрхийлж, эсрэг этгээдээ

«

С.Цогтсайхан өөрийн гэсэн найруулгын өнгө аясыг нэгэнт олж чадсан сэтгүүлч байжээ. Тэгэхдээ энэхүү найруулгын өнгө аяс нь 1970-1980-аад оны сэтгүүл зүйд зонхилж байсан, одоо ч анзаарагдсаар байгаа уянгалуулах, уран сайханжуулах арга хэлбэрээс эрс өөр, элдэв чимэг "зүүсгэл" багатай энгийн товч бичлэг юм. Үүнийг "Сэтгүүлч Цогтсайханы бичлэгийн хэв маяг", эсвэл "Цогтсайханы найруулга" хэмээн нэршүүлж хэвшсэн ч болно.

»

лэл нь түүний бүтээлүүдийн эмхтгэлд ороогүй байна.

С.Цогтсайханы улс төрийн нийтлэлүүдэд чухал орон зай эзэлдэг бүтээлүүд нь ухуулга сурталчилгааны өгүүлэл, нийтлэл, ярилцлагууд юм. Үүнд "Би яагаад Монголын ардчилсан холбоонд элссэн бэ?", "МоАХ-ны тухай бид юу мэдэх вэ?", "Бид диваажин амлаагүй" зэрэг өгүүлэл, ярилцлагыг нэрлэж болно.

С.Цогтсайханы "Би яагаад Монголын ардчилсан холбоонд элссэн бэ?" өгүүлэл "Монголд ардчилал ялан тогтнох энэ агшныг алдаж болохгүй. Хэрэв тэгвэл нэг намын дарангуйлал дахин нөмрөх болно. Улсын минь түүхэнд дахиж үл олдох энэ завшааныг

нүдний цөцгий мэт хайрлавал зохино. Монголчууд бид бүхэл үеийн турш хоорондоо дайсагналаа. Үүний дүнд гагцхүү ард түмэн хохирсноос биш ямбатнууд хохирч байгаагүй. Одоо болье! Одоо хүн шиг амьдаръя.

Эрх чөлөөгөө чухалчилъя. Айдсын хар үүлийг ярж, үнэний гэгээ тусгасан Монголын Ардчилсан Холбооны гэрэлд эрх чөлөөтэй, эрүүл ухаантай, үнэнийг хэлж чаддаг, үнэнээр амьдарч чаддаг хүний дайтай хүн явахыг хүссэн юм аа. Монголын Ардчилсан Холбоонд гишүүнээр элссэн учир гэвэл ийм байна” хэмээн төгсөж байна.

Энэ нь Монголд тогтмол хэвлэл үүсч буй болж байсан эхлэл үеийн Д.Бодоо, Ж.Цэвээн тэргүүтний ухуулан сурталчилсан агуулга бүхий нийтлэлүүдийг зарим талаараа сануулж байна.

Өмнө дурдсан нийтлэлээ С.Цогтсайхан МоАХ хэмээх улс төрийн байгууллагад яагаад элсэх болсон тухайгаа хувь хүн өгүүлж буй хэлбэрээр бичсэн бол “МоАХ-ны тухай бид юу мэдэх вэ?” өгүүллээ болохоор МоАХ-ны тухай буруу ташаа ойлголт, суртал ухуулгын эсрэг бичсэн нь тодорхой байна. Тэгэхдээ тус байгууллагын эгнээнд ямар хүмүүс байдгийг дурдаад, бусдын санхүүжилтгүй, өрөөлийн дэмжлэггүй, цэвэр итгэл үнэмшил, үзэл бодлоороо нэгдсэн байгууллага хэмээн тайлбарласан байна. Энэ бол улс төрийн, тэр дундаа цэвэр ухуулгын шинжтэй өгүүлэл юм. Энэ нь уг өгүүлэл “МоАХ гэдэг үгийг сонсоод өлсгөлөн, цуглаан, жагсаал өдөөсөн бусармаг залуус гэж жихүүцэх хүн олон бий. Тэднийг гудамжныхан, люмпенүүд гэж доромжлох нь энүүхэнд. Тийм ээ. МоАХ-ны эгнээнд гудамжныхан болон люмпенүүд бий. Төдий хэмжээгээр эрдэмтэд болоод ухаантнууд бас

байдаг юм. Багш, эмч, цэрэг, дарга, жолооч, барилгачин, пүүсийн эзэн, зарц, ажилчин, малчин гээд нийгмийн бүх давхаргын төлөөлөгчид хамрагддаг. Энэ ч утгаараа Монголын бүх ард түмний хөдөлгөөн, улс төрийн байгууллага гэж анхныхаа их хурлаар тунхагласан юм.

МоАХ-ны анхны гишүүд тэмцлээ явуулахдаа ямар нэгэн хүчний дэмжлэгт найдаж байсангүй. Хэн нэгэн баяны мөнгөөр санхүүжсэнгүй. Ардчилал нийгмийн тогтолцоог бий болгох зорилтоо хэнээс ч асуусангүй. Жинхэнэ зүрх сэтгэл, итгэл зоригоороо нэгдэж чадсан юм. 1990 онд улсын хэмжээнд МоАХ-ны 300 гаруй салбар зөвлөл байгуулагдаж, нийтдээ 120 мянга орчим хүн гишүүнээр элссэн байлаа. Энд нэг зүйлийг тодруулж хэлэх шаардлагатай. МоАХ-ны гишүүнчлэлийн байдлыг авч үзвэл Монголын бүх намын төлөөлөл багтсан байдаг. Энэ нь аль ч намын гишүүн МоАХ-д элсэж ирсэн, элссээр ч байгааг харуулж байгаа юм. Ер нь МАХН-аас бусад намын дийлэнх нь МоАХ-ноос гарсан гэж хэлж болно” хэмээн эхэлж буйгаас тодорхой байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуульд П.Очирбатыг Ардчилсан хүчнээс нэр дэвшин өрсөлдөх үеэр гаргасан нэр дэвшигчийн “Ерөнхийлөгч” сонинд С.Цогтсайхан “Талд асаасан лаа” гарчигтай өгүүлэл бичиж нийтлүүлж байсан нь ч мөн л ухуулгын бүтээлийн төрөлд хамаарна. Тэрээр энэ өгүүлэлдээ Монголын ардчиллыг талд асаасан лаатай зүйрлээд, энэхүү эмзэг турьхан гэрлийг салхиар давтан унтраачихгүйн тулд ардчилсан хүчнээс нэр дэвшигчийг сонгохыг уриалж байв.

С.Цогтсайхан өөрөө Монголын ардчилал хэмээх талд асаасан лааг хөндлөнгийн хүйс салхинд унтраалгачих-

гүйн тулд улс төрийн сэдвээр тасралтгүй бичиж туурвиж, тэгэхдээ улс төрийн давс хужир нь чангадсан бүтээлдээ ч сэтгүүлчийн уран чадвар, сэтгэлгээний өвөрмөц байдлаа шингээж чаддаг уран бүтээлч байв.

Хэл найруулгын онцлог. С.Цогтсайхан өөрийн гэсэн найруулгын өнгө аясыг нэгэнт олж чадсан сэтгүүлч байжээ. Тэгэхдээ энэхүү найруулгын өнгө аяс нь 1970-1980-аад оны сэтгүүл зүйд зонхилж байсан, одоо ч анзаарагдсаар байгаа уянгалуулах, уран сайханжуулах арга хэлбэрээс эрс өөр, элдэв чимэг “зүүсгэл” багатай энгийн товч бичлэг юм. Үүнийг “Сэтгүүлч Цогтсайханы бичлэгийн хэв маяг”, эсвэл “Цогтсайханы найруулга” хэмээн нэршүүлж хэвшсэн ч болно.

Найруулгын талаар МУБИС-ийн монгол хэл шинжлэлийн тэнхимээс эрхлэн хэвлүүлсэн “Орчин цагийн монгол хэл” хамтын бүтээлд найруулгын тухай янз бүрийн тодорхойлолтуудыг тоймлосны дотор “...Ярих, эсвэл бичиж нийтлэх тогтсон арга маяг... Тухайн хувь хүний ярих, бичих арга барил...”⁵ гэсэн байна. Тэгэхээр тухайн сэтгүүлч, хувь хүнээр нэршсэн бичлэгийн арга хэлбэр байж болох бөгөөд ингэж нэршүүлэхийн тулд тухайн сэтгүүлч давтагдашгүй өвөрмөцөөр бичих шаардлагатай болно. С.Цогтсайхан энэ шалгуурыг давж чадсан сэтгүүлч байсан гэж үзэж байна. Энэ нь түүний өвөрмөц сэтгэлгээ, өөрийн санаа бодлоо хурц тод илэрхийлэх чадварын үр дүн юм.

Ишлэл

- ¹ Батбаатар Ж. 2010. Суурь сэтгүүл зүй. УБ., 135 дахь тал.
- ² Батбаатар Ж., Амартүвшин С., Одмандах М. 2010. Практик сэтгүүл зүй. УБ., 31 дэх тал.
- ³ Батбаатар С. Зураглал сэтгүүл зүйн бичлэгийн нэгэн арга, хэрэглүүр болох нь. УБ., 85 дахь тал.
- ⁴ Норовсүрэн Л. 1996. Монголын тогтмол хэвлэлийн бичлэгийн төрөл, зүйл. УБ., 145 дахь тал.
- ⁵ Сүхбат Г., Батбаатар С. 2007. Найруулах эрдэм, хэл ярианы соёл. УБ., 19 дэх тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Батбаатар Ж. 2009. Практик сэтгүүл зүй. УБ.
2. Батбаатар Ж. 2008. Суурь сэтгүүл зүй. УБ.
3. Зулькафиль М. 2009. Сэтгүүлчийн ур чадвар. 1, 2-р боть.
4. Норовсүрэн Л. 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. УБ. Гутгаар дэвтэр.
5. Цогтсайхан С. 2003. Хонхны дуу. УБ.
6. Цогтсайхан С. 1999. Тарчлаан. УБ.

Резюме

Настоящая статья посвящена анализу творчества известного монгольского журналиста, одного из первых “ласточек” демократической революции 1990 года С.Цогтсайхана. Его публикации и произведения занимают почётное место в сокровищнице монгольской журналистики. Способность дать точные и информационно насыщенные заголовки своим публикациям, умение создать красочный, живой человеческий образ являются кредитной карточкой С.Цогтсайхана.